

БОР-ӨНДӨР ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ

БАТЛАВ
Ц.ГАНХҮҮ

БОР-ӨНДӨР СУМЫН БОР-ӨНДӨР ЦОГЦОЛБОР СУРГУУЛЬ

ОГНОО 2024.03.22

БОР-ӨНДӨР ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН “ДОТУУР
БАЙРНЫ ХООЛ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ”
НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендэр шалгаруулалтын нэр: Бор-өндөр цогцолбор сургуулийн дотуур байранд
хоол хүнс худалдан авах

Тендэр шалгаруулалтын дугаар: ХЭАБӨЦС/20240202001

Бор-өндөр сум
2024 он

Нэг. ТЕНДЕРИЙН ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: **2024-04-03**

Бор-Өндөр сумын Бор-Өндөр цогцолбор сургууль нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **дотуур байрны хоол хүнс нийлүүлэх тендер**-т үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Тендерийн баримт бичгийг (**хүсвэл нэмэлт хувийг**) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **50,000** төгрөгөөр худалдан авч болно. Төлбөрийн хийх хэлбэр: **Дансаар тушаана.**

Банкны нэр: **Төрийн сан банк**

Дансны дугаар /төгрөгөөр/: **100182715160 /Хэнтий Бор-өндөр 11 жилийн сургууль нэмэлт санхүүжилтийн харилцах/**

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 5 хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн саналыг **2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 10: 45 цагаас өмнө Бор-Өндөр сум 1-р баг, БӨЦС-ийн А байр 1 давхар багш нарын өрөөнд** ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2024 оны 04 дугаар сарын 10-ны өдрийн 12:45 цагт** БӨЦС-ийн А байр 2 давхар лекцийн танхимд нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: Тооцохгүй.

Гадаадын этгээд оролцох эсэх: Үгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Бор-Өндөр сум 1-р баг, БӨЦС-ийн А байр
1 давхар багш нарын өрөө 99548881, 95091220**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар нь: Тендер шалгаруулалтын нэр: Бор-өндөр цогцолбор сургуулийн “дотуур байрны хоол хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх” нийлүүлэгчийг <i>сонгон шалгаруулах</i></p> <p>Тендерийн дугаар: ХЭАБӨЦС/202402001</p> <ol style="list-style-type: none"> Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагыг харуулах урьд хийгдсэн гэрээний хуулбар хувь болон нотлох баримт: сүүлийн 1 жил Ашигтай ажилласан байх жилийн тоо: Сүүлийн 1 жил <p>Тусгай зөвшөөрөл шаардлагатай Тендер нээснээс хойш 30 хоногийн туршид хүчинтэй байна. Тендерийн валют: [Төгрөг байна] Хувилбарт тендер ирүүлэхийг “зөвшөөрөхгүй” Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад “тохируулахгүй.”</p>
ТӨӨЗ 2.1	<p>Захиалагч тендерийг хүлээн авах хаяг нь: Хэнтий аймаг, Бор-Өндөр сум, БӨЦС “А” байр багш нарын өрөө Тендер хүлээн авах этгээд: Ш.Гангэрэл 99548881, 95091220</p> <p>Байгууллагын хаяг: Хэнтий аймаг, Бор-Өндөр сумын 1-р баг “БорӨндөр цогцолбор сургууль”.</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 1-р давхар Аймаг, хот: Хэнтий аймаг Улс: Монгол Улс</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Байшин, гудамжны нэр: Бор-Өндөр сумын 1-р баг БӨЦС”А” байр Давхар болон өрөөний дугаар: 2 давхар, Лекцийн танхим Аймаг, хот: Хэнтий аймаг, Бор-Өндөр сум Шуудангийн дугаар: Ш/х 42 Улс: Монгол Улс Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: 2024 оны 04 сарын 10-ны өдөр Цаг: 10 цаг 45 минут</p>

<p>ТӨӨЗ 2.3</p>	<ol style="list-style-type: none"> 1. Тендерт оролцогч дараах нэмэлт материалуудыг өөрийн тендерт ирүүлнэ. Үүнд: 2. Улсын бүртгэлийн гэрчилгээ 3. Холбогдох тусгай зөвшөөрлүүд 4. Татварын газрын тодорхойлолт 5. Лабораторийн шинжилгээ, гарал үүслийн бичиг зэрэг, шаардлагатай бичиг баримтууд 6. Банкны харилцах дансны хуулга 7. Харьяа шүүхийн тодорхойлолт 8. Харьяа нийгмийн даатгалын газар /тасаг/-н тодорхойлолт цаасаар 9. Тендерийн баримт бичгийн хуудас бүрийг нэг бүрчлэн дугаарлаж тамга дарж баталгаажуулж ирүүлэх 10. Тендер шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор тендерийн гаднах болон доторх дугтуйд дараах нэр, ялгах дугаарыг гаргацтай тэмдэглэнэ: 11. Тендерийн материал нь дугтуйнд хийсэн байна. 12. Тендерийн нөхцлийг ханган, лацдаж битүүмжилсэн байна..Тендерт оролцогч нь захиалагч байгууллагын нэрийг дугтуйны зүүн дээд буланд том үсгээр, гаргацтай бичсэн байна. 13. Тендерт оролцогч нь өөрийн байгууллагын нэр хаягийг дугтуйны баруун доод буланд бүрэн, зөв гаргацтай бичсэн байна. 14. 6.Захиалагч байгууллага нь тендерийн нэр болон дугаарыг дугтуйны төв хэсэгт байрлуулж бичсэн байна.
<p>ТӨӨЗ 6.2</p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр,бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p>Дэс дугаар: Бор-өндөр цогцолбор сургуулийн “дотуур байрны хоол хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх”</p> <ol style="list-style-type: none"> 1.1. Мах, махан бүтээгдэхүүний багц 1.2. Гурил гурилан бүтээгдэхүүний багц- 1.3. Сүү, сүүн бүтээгдэхүүний багц- 1.4. Жимс, Хүнсний ногооны багц-

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Техникийн тодорхойлолтын хураангуй.

Нийлүүлэх болон холбогдох үйлчилгээнд дор дурьдсан техникийн тодорхойлолт стандартад нийцсэн байна.

Нэр төрлийн дугаар	Бараа болон холбогдох үйлчилгээний нэр	Техникийн тодорхойлолт болон стандарт
1	Мах махан бүтээгдэхүүний багц	<p>Нийлүүлэгдэх мах нь стандартын шаардлага хангасан байна.</p> <ul style="list-style-type: none">• Мах нь шинэ, чийгээ алдаагүй, технологийн дагуу цэвэрлэж, хөлдөөсөн, гадаргуу цэвэр, гадны үнэр, амт байхгүй байна. (шивтэр, бензин гэх мэт, хэвлийн хөндийд дайвар бүтээгдэхүүн болон махны ялгадасгүй байх)• Лабораторийн шинжилгээний бичиг болон гарал үүслийн бичигтэй байна.• Шаардлагатай тохиолдолд захиалагч байгууллага шинжилгээнд давтан оруулсан тохиолдолд шинжилгээний төлбөрийг нийлүүлэгч тал хариуцах (төлбөр төлөх)• Хүнсний тухай хууль, Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлсэн байна.• Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар хүргэж ирнэ.• Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгслийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна.
2	Жимс, Хүнсний ногоо	<p>Ерөнхий зүйл: Нийлүүлэгдэх ногоо нь орон нутагт тариалагдсан, стандартын шаардлага хангасан байна.</p> <ul style="list-style-type: none">• Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар хүргэж ирнэ.• Хорхойд идэгдээгүй байх• Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгслийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна.• Хүнсний тухай хууль, Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлсэн байна.• Лабораторийн шинжилгээний болон гарал үүслийн бичигтэй байна.

		<p>2.1 Барааны нэр: Төмс</p> <ul style="list-style-type: none"> • Төмсний диаметр 6-7 багагүй, 1ш төмсний дундаж жин 180-250 гр байх • Гэмтэж муудаагүй, зөөлрөөгүй, соёолоогүй, хайрагдаагүй, гадны үнэр амтгүй, элдэв механик хольцгүй байна. /гадаргууд нь шороо чулуу наалдаагүй байх/ • Стандартын шаардлага хангасан үрээр тарьсан байх. <p>2.2 Барааны нэр: Байцай □ Байцай нь нягтрал сайтай, муудаж гэмтээгүй гадны үнэр амтгүй, ялзраагүй байх.</p> <ul style="list-style-type: none"> • Байцайны дундаж жин нь 2-2.5кг байх • Гадаргууны илүүдэл навч, голыг цэвэрлэсэн байна. <p>2.3 Барааны нэр: Бөөрөнхий сонгино</p> <ul style="list-style-type: none"> • Ялзарч муудаагүй, хатаж чийгээ алдаагүй, ааг амт сайтай, гадны үнэр амтгүй, элдэв механик хольцгүй байна. • Орон нутагт тариалсан байна. □ Соёлж, хөгшрөөгүй байхаас гадна 1ш сонгины дундаж жин 100-150гр байх. • 100кг сонгино бүрт 2 кг хорогдол тооцож байх <p>2.4 Барааны нэр: Лууван</p> <ul style="list-style-type: none"> • 1 ш луувангийн дундаж жин 200-300 гр байх ба механик элдэв хольцгүй, зөөлөрч муудаагүй, чийгээ алдаагүй соёолоогүй, гадны үнэр амтгүй байна. • Лууванд агуулагдах коратин болон бусад төрлийн амин дэм нь алдагдаагүй, багавтар чихэрлэг амттай улбар шар өнгөтэй байна. • 100кг лууван бүрт 2 кг хорогдол тооцож түүнтэй тэнцэх хэмжээний лууван нэмж олгоно. <p>2.5 Барааны нэр: Нарийн ногоо \өргөст хэмх, улаан лооль, чинжүү, сармис зэрэг\</p> <ul style="list-style-type: none"> • Хэт хөгшрөөгүй, чийгээ алдаагүй, хөгц үүсч муудаагүй, шинэ байна. • Өргөст хэмх нь цайвар ногоон өнгөтэй гашуун биш, дундаж жин нь 250-280гр, 4-5 см диаметртай байна. • Улаан лооль нь бяцарч гэмтээгүй, хэт исгэлэн гашуун биш, болц гүйцсэн байх. <p>Барааны нэр: 2.6 Жимс, жимсгэнэ. (үзэм, чацаргана)</p>
--	--	--

		<ul style="list-style-type: none"> • Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна. • Зориулалтын сав баглаанд савласан байна. <ul style="list-style-type: none"> □ Эрүүл ахуйн шаардлага хангасан байна. (элдэв өнгө амт үнэргүй, хатаж хорчийгоогүй, хөгцгүй, шороо чулуугүй, хог хаягдалгүй дээд зэргийн чанарынх байна) • Шинэ жимс нь исээгүй, няцраагүй, хорхой идээгүй, хөгцрөөгүй, иш, навчгүй байна.
3	Сүү сүүн бүтээгдэхүүний багц	<p>Ерөнхий зүйл: Нийлүүлэгдэх сүү, сүүн бүтээгдэхүүн нь стандартын шаардлага хангасан байна.</p> <ul style="list-style-type: none"> • Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж ирнэ. • Зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. • Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгслийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна. • Хүнсний тухай хууль, Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлсэн байна. • Лабораторийн шинжилгээний болон гарал үүслийн бичигтэй байна. □ Нийлүүлэгдэх сүү, сүүн бүтээгдэхүүн нь эх орны бүтээгдэхүүн байна. <p>3.1 Барааны нэр: Хуурай сүү □ Эрүүл ахуйн шаардлага хангасан саванд савлагдсан байна.</p> <ul style="list-style-type: none"> • Гадны үнэр, амт байхгүй, тослог зохих түвшинд байх, шинэ байна. • Тээвэрлэлтийн горимыг баримтална. <p>3.2 Барааны нэр: Шингэн сүү □ Эрүүл ахуйн шаардлага хангасан саванд савлагдсан байна</p> <ul style="list-style-type: none"> • Гадны үнэр, амт байхгүй, тослог зохих түвшинд байх, шинэ байна. /Малчин өрхөөс авсан тохиолдолд хольцгүй байх./ □ Тээвэрлэлтийн горимыг баримтална. <p>3.3 Барааны нэр: Тараг аарц, хорхой ааруул</p> <ul style="list-style-type: none"> • Эрүүл ахуйн шаардлага хангасан саванд савлагдсан байна • Гадны үнэр, амт байхгүй, тослог зохих түвшинд байх, шинэ байна. /Малчин өрхөөс авсан тохиолдолд хольцгүй байх./ • Тээвэрлэлтийн горимыг баримтална.
		<ul style="list-style-type: none"> • Гадны үнэр, амт байхгүй, тослог зохих түвшинд байх, шинэ байна. /Малчин өрхөөс авсан тохиолдолд хольцгүй байх./ • Тээвэрлэлтийн горимыг баримтална.

4	<p>Гурил, гурилан бүтээгдэхүүн</p>	<p>Ерөнхий зүйл:</p> <ul style="list-style-type: none"> • Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна. <input type="checkbox"/> Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж ирнэ. • Зориулалтын сав, баглаанд савласан байна. • Зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. • Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгслийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна. • Хүнсний тухай хууль, Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлсэн байна. <input type="checkbox"/> Хадгалалтын хугацаа дуусаагүй бүтээгдэхүүн байх • Лабораторийн шинжилгээний бичигтэй байна. <input type="checkbox"/> Талхны хэмжээ 800 граммаас багагүй байна. <input type="checkbox"/> Бутрамтгай биш, нягтаршил, болц сайтай байна. • Нийлүүлэх нарийн боов нь тослог давхраат, өндгөн, хөөмөл, зуурмагаар бэлтгэгдсэн олон төрөл байна. <input type="checkbox"/> Хэлбэр дүрсээ алдаагүй, өнгө үзэмж сайтай шинэ байна. <p>4.1 Барааны нэр: Гоймонгийн төрөл</p> <ul style="list-style-type: none"> • Нийлүүлэгдэх гоймон нь үйлдвэрийн аргаар боловсруулагдсан олон улсын стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн байна. • 0.35 - 5 кг-аар савлагдсан, чийг аваагүй, хуурай, хөгцөрч муудаагүй, үүрч гэмтээгүй, хэлбэр дүрсээ алдаагүй, шинэ байна. <input type="checkbox"/> Өндөгний хольцтой, урсамтгай биш шинж чанартай байна. • 3-аас доошгүй төрөл байна. (шпагетти, алейка, лапша, гэх мэт) <p>4.2 Барааны нэр: Будааны төрөл (цагаан, гурвалжин, шар,)</p>
		<ul style="list-style-type: none"> • MNS 0142:1985 техникийн шаардлага хангасан байна. • Гадны механик хольцгүй ба үнэр амтгүй, бяцарч хуваагдаагүй байна. • Будаа нь том ширхэгтэй, агшаахад нялцаахгүй байх <p>4.3 Барааны нэр: Гурил</p> <ul style="list-style-type: none"> • MNS0244:2009 техникийн шаардлага хангасан байна. • Гадны механик хольцгүй ба үнэр амтгүй, хөгцөрч муудаагүй байна. • 1, 2-р зэргийн, баяжуулсан гурил байна. • 25кг-аар савлагдсан.

		<ul style="list-style-type: none"> • Чийгээ алдаагүй, шинэ байна.
5.	Бусад, хуурай хүнс	<p>5.1 Барааны нэр: Ургамлын цэцгийн тос <input type="checkbox"/></p> <p>Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна.</p> <ul style="list-style-type: none"> • Зориулалтын сав баглаанд савласан байна. <input type="checkbox"/> Эрүүл ахуйн шаардлага хангасан байна. (элдэв өнгө амт үнэргүй байна) <p>5.2 Барааны нэр: Масло <input type="checkbox"/> Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна.</p> <ul style="list-style-type: none"> • Зориулалтын сав баглаанд савласан байна. • Тослогийн хэмжээ 82%-аас багагүй байна. • Эрүүл ахуйн шаардлага хангасан байна. (хайлаагүй, хөгцгүй, элдэв өнгө, амт үнэргүй байна) <p>5.3 Барааны нэр: Элсэн чихэр</p> <ul style="list-style-type: none"> • Цагаан элсэн чихэр /дээд зэрэг/ 99,7 “Z-ээс багагүй эргэлтийн өнцөгтэй, цэвэршүүлсэн ба талстжуулсан сахароз • Цагаан элсэн чихэр /1-р зэрэг/ 99,5 “Z-ээс багагүй эргэлтийн өнцөгтэй, цэвэршүүлсэн ба талстжуулсан сахароз <p>5.4 Барааны нэр: Бусад хүнс</p> <ul style="list-style-type: none"> • Каш • Пүнтүүз • Хуурай цай • Исгэгч
		<p><input type="checkbox"/> Давс</p> <ul style="list-style-type: none"> ➤ Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна. ➤ Зориулалтын сав баглаанд савласан байна. ➤ Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгслийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна.

		<ul style="list-style-type: none">➤ Хүнсний тухай хууль, Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлсэн байна.➤ Лабораторийн шинжилгээний бичигтэй байна. <p>Эрүүл ахуйн шаардлага хангасан байна./хөгц амтгүй байна./</p>
--	--	---

2024 онд шаардагдах хүнсний материалын тооцоо, үнийн судалгаа

2024.03.12

№	Хүнсний материалын нэрс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
I. Мах, махан бүтээгдэхүүн					
1	Үхрийн мах	кг	544	12000	6,528,000
2	Тахианы мах	кг	40	11000	440,000
3	Нухаш	ш	6	16000	96,000
Дүн					7,064,000
II. Гурил,гурилан бүтээгдэхүүн					
4	Гурил	кг	55	62400	3,432,000
5	Гоймон /лапша/	кг	50	16700	835,000
6	Гоймон /мушгиа/	кг	50	11000	550,000
7	Пүнтүүз	ш	55	3000	165,000
8	Цагаан будаа	кг	300	3750	1,125,000
9	Гурвалжин	кг	55	6750	371,250
10	Каш	кг	50	4900	245,000
11	Печень		200	2300	460,000
12	Шар будаа	кг	40	2650	106,000
Дүн					7,289,250
III. Сүүн бүтээгдэхүүн					
13	Сүү /хуурай/	кг	80	15000	1,200,000
14	Сүү /шингэн/	л	130	5500	715,000
15	Давс	ш	60	1500	90,000
16	Сахар	кг	100	4900	490,000
17	Ургамлын тос	ш	170	6000	1,020,000
18	Цайны идээ	ш	30	5800	174,000
19	Исгэгч	ш	20	8100	162,000
20	шөлний байцаа	ш	30	5600	168,000
21	Варень	ш	30	9150	274,500
22	Үзэм	кг	45	9800	441,000
23	Чацаргана	кг	40	7000	280,000
24	Аарц	кг	38	6000	228,000
25	Масло	кг	45	9800	441,000
Дүн					9,475,050
IV. Жимс,ногоо бүтээгдэхүүн					
26	Төмс	кг	1100	1200	1,320,000
27	Лууван	кг	220	1500	330,000
28	Байцаа	кг	490	1800	882,000
29	Сармис	кг	20	9000	180,000
30	Сонгино	кг	220	3250	715,000
Дүн					3,428,000
Дүн					27,256,300
Нийт дүн					27,256,300

2. Баглаа боодол

1: Махыг тээвэрлэх, хадгалах явцад гадны нөлөөллөөс хамгаалан гадуур нь гялгар уутаар ороосон байх

2: Хүнсний ногоо тус тусдаа савлагдсан, гадны шороо чулууны хольцгүй байх 3: Сүү, сүүн бүтээгдэхүүнийг зориулалтын таглаатай ариутгасан саванд савлаж тээвэрлэх ба гашилж муудахаас хамгаалах

4: Талх, нарийн боовыг зориулалтын машинаар тээвэрлэхдээ тус тусад нь савлаж битүүмжилсэн байх

5: Хуурай хүнсний багцад орсон бүтээгдэхүүн тус бүр зориулалтын саванд савлагдсан байх ба гадны тоос шороо орохоос сэргийлэн, хадгалах хугацаа нь тодорхой заагдсан, тээвэрлэлтийн явцад гэмтэж муудах, хагарч асгарахаас хамгаалагдсан байх

Бараа хүргэх газар: БӨЦСургуулийн дотуур байр

Тайлбар:

1. Мах бүтээгдэхүүнд худалдан борлуулахаар зөвшөөрөгдсөн хонины мах, хиам, элгэний нухаш орно. Махны дайвар болон лаазалсан, дахин боловсруулсан махан бүтээгдэхүүн хамаарахгүй.
2. Сүү, сүүн бүтээгдэхүүн гэдэгт хуурай болон шингэн сүү, тараг, аарц, хорхой ааруул хамаарна.
3. Гурил, гурилан бүтээгдэхүүнд бялуу, кекс хамаарахгүй.
4. Төмс, хүнсний ногоо гэдэгт дарсан ногоо буюу лаазалсан, дахин боловсруулсан бүтээгдэхүүн хамаарахгүй.
5. Будаа гэдэгт цагаан, шар, гурвалжин бүтээгдэхүүн хамаарна.
6. Жимс жимсгэнэ гэдэгт компот, жимсний чанамал, хатаасан жимс хамаарахгүй.

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.

2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан моо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[moo]**¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)² 9.1. Алданги оногдуулах хувь: **[moo]**
- Алдангийн нийт дүн: **[moo]**

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]